

ӨМНӨГОВЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2009 – 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр томилогдон ажиллаж байгаа аймгийн Засаг даргаас Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутагт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөр, тогтоол шийдвэрүүд тэдгээрийг дагалдан гарсан дэд хөтөлбөрүүд, аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, ажилгүйдэл ядуурлыг бууруулах хөтөлбөр , 2008 оны орон нутгийн сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөр болон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал санаачлагыг үндэслэн 2009 – 2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсрууллаа.

Өмнөх 4 жилд аймгийн эдийн засаг санхүүгийн чадавхи сайжирч, бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядууралтай тэмцэх ажлыг орон нутгийн түвшинд оновчтой, үр дүнд тулгуурласан хэлбэрээр хэрэгжүүлэн, бүс нутгийн түвшинд аймгийн тэргүүлэх чиг хандлагыг тодорхойлж, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлсэн төдийгүй цааш үргэлжлүүлэн хийх олон бүтээлч ажлын үндэс суурийг тавьсан юм. Энэхүү үйл ажиллагааны залгамж чанарыг хадгалж , өнөөгийн өөрчлөгдөн хөгжиж байгаа эдийн засаг нийгмийн байдал, хүсэн хүлээгдэж байгаа үр дүнтэй уялдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно.

Өмнөговь аймгийг 2009-2012 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь ирэх 4 жилд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ

- Хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулна.
- Орон нутгийн газрын баялагыг түшсэн уул уурхайн салбарын хөгжлийг түргэтгэж, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж, түүнээс олсон орлогоос нутгийн иргэдэд давуу эрхтэйгээр хувь хүртээнэ
- Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх замаар ажилгүйдэл ядуурлыг өнөөгийн түвшнээс тууштай бууруулна
- Архидалт, түүнийг бий болгож буй хүчин зүйлсэд дорвитой өөрчлөлт хийх замаар иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ
- Иргэдэд үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага сахилгыг өндөржүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, суралцагч манлайлагч байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлнэ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгч төвтэй, хариуцлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулан, эрүүл мэндийн байдлыг сайжруулах зорилтын хүрээнд:

1.1.1. Эрүүл мэндийн мастер төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлнэ.

1.1.2. Хүн амын өвчлөл нас баралтыг бууруулах зорилгоор эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ.

1.1.3. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах, эрсдлийн менежментийг бүрдүүлж ажиллана.

1.1.4. Даланзадгад суманд "Говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв", Цогтцэций суманд "Сум дундын эмнэлэг" байгуулах ажлыг судалж шийдвэрлэнэ.

1.1.5. Нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгийн оношилгоо эмчилгээ, лабораторийн чадамжийг сайжруулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

1.1.6. Нэгдсэн эмнэлэг болон зарим сумдын эмнэлэгт нөхөн сэргээх, уламжлалт эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээний тасаг, кабинетуудыг шинээр байгуулах буюу өргөтгөж тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1.1.7. Аймгийн хүн амыг нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулан амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгоно.

1.1.8. Хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын эмнэлгийн үйлчилгээг нэвтрүүлэн өвчнийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.1.9. "Эрүүл эхээс эрүүл хүүхэд" зарчмыг хэрэгжүүлж, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг хөгжүүлнэ.

1.1.10. Эмнэлгийн мэргэжилтний хангалт, ёс зүй, хариуцлага, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, тогтвор суурьшилтай бүтээлч ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.11. Өрхийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж эмнэлгийн тусламжийн хүртээмжийг сайжруулна.

1.1.12. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж БЗДХ, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын эрсдлээс урьдчилан сэргийлнэ.

1.1.13. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэн, худалдан авах үйл ажиллагаагаар нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг сайжруулна.

1.1.14. Сумдад ажиллаж байгаа эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг тогтворжуулна.

1.1.15. Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлнэ

1.1.16. Аймгийн баг тамирчдыг Олон улс, улсын чанартай тэмцээн, уралдаанд оролцоход байгууллага, хамт олны дэмжлэгт оролцоог нэмэгдүүлнэ.

1.1.17. Үндэсний спортын аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, үндэсний спортын цогцолборыг шинээр байгуулна.

1.2 Иргэдэд чанартай ажиллаж амьдрах хэрэгцээг нь хангахуйц албан болон албан бус боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй тасралтгүй үзүүлж, орчны стандарт болон хүний нөөцийн ур чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

1.2.1. Аймгийн Боловсролын мастер төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлнэ.

1.2.2. Монгол бичиг, Англи хэл, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.2.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой болгох бодлого барьж ээлж дараатай хэрэгжүүлнэ.

1.2.4. Их дээд сургууль, коллежийн салбар, хувийн сургууль, цэцэрлэг, дотуур байр байгуулах чиглэлээр ТББ, хувийн хэвшлээс гаргасан санал санаачлагыг дэмжиж хамтарч ажиллана.

1.2.5. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 99.9%, суурь боловсролын хамран сургалтыг 96%-д хүргэнэ.

1.2.6. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд сурагч, эцэг эх, орон нутгийн удирдлага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж "Хүүхдэд ээлтэй орчин" бүрдүүлнэ.

1.2.7. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын чанар, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг бүрдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, боловсролын чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх орчинг бий болгоно.

1.2.8. Мэргэжлийн багшийн хангамжийг сайжруулах, тэдний ажлын үр дүнг тооцсон нэмэгдэл урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

1.2.9. Цогцолбор болон бүсийн төв, түшиц сургуулиудыг багшийн мэргэжил дээшлүүлэх, хамтран ажиллах төв болгон сургууль бүрт “Хүүхэд хөгжлийн төв” байгуулна.

1.2.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн сургалтын бааз, дадлагын байраар хангаж, технологийн шинэчлэл хийн, оюуны өндөр чадамжтай, мэдээлэлжсэн, мэргэшсэн ажилтан бэлтгэх төв болгон хөгжүүлнэ.

1.2.11. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн сурагчдын "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгон өргөжүүлж хэрэгжүүлнэ.

1.2.12. Орон нутгийн шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.2.13. Боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.3. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл урлагийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

1.3.1. Соёл, урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

1.3.2. Соёл урлагийн байгууллагуудаас зохион байгуулагдаж байгаа олон талт ажлын чанар, хүртээмжийг сайжруулан, үйлчилгээнд шинэ арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

1.3.3. Аймгийн хэмжээний соёлын өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар, дурсгалуудын судалгааг баяжуулж, хамгаалалтанд авна.

1.3.4. Төв, хөдөөгийн музейн сан хөмрөгийг баяжуулж, сумдын орон нутаг судлах кабинетыг тохижуулна.

1.3.5. Аймгийн Музейг өргөтгөж, тэмээ, чулууны үзэсгэлэнгийн танхимыг шинэчлэн байгуулна.

1.3.6. Номын сангуудын фондыг баяжуулж, сумдын номын санг электрон программаар хангана.

1.3.7. Өмнөговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулж, түүхийн цуврал ном хэвлүүлж, кино бүтээн иргэдийн хүртээл болгоно.

1.3.8. Ардын уламжлалт урлагийг дэмжин хөгжүүлнэ.

1.3.9. Нутгийн ая аялага, биет өвийг хадгалан үлдсэн ардын авьяастнуудын уран бүтээлийн хуурцаг хийж, нийтийн хүртээл болгоно.

1.3.10. Соёл, урлагийн ажилтан, ардын авьяастныг дэмжин мэдлэг боловсролыг нь дээшлүүлж, шинэ боловсон хүчин бэлтгэнэ

1.3.11. Соёл, урлагийн байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.3.12. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүний хөгжлийн зохистой бодлогоор нутгийн иргэдийн амьдралын чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

1.4.1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, зуучлалыг сайжруулж, үйлчилгээг боловсронгуй болгон 4200 хүнийг ажилд зуучилна.

1.4.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд, жижиг дунд үйлдвэрүүд, банк санхүүгийн байгууллагуудтай хамтран 4000 шинэ ажлын байр бий болгож, ажилгүйдлийн түвшинг 2.0 хувьд хүргэж бууруулна.

1.4.3. Мэргэжлийн боловсрол олгох сургалтуудыг чанаржуулан зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар сайтай 2000 мэргэжилтэй ажилтныг бэлтгэнэ.

1.4.4. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ажилгүйчүүдийн нас, биеийн хүчний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.4.5. Өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулж, өрх бүрийг орлогын эх үүсвэртэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлэн ядуурлыг тууштай бууруулна.

1.4.6. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлж, хүн амын бүлгүүдэд хүрсэн оновчтой үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.4.7. Нутгийн баялагаас иргэн бүр адил тэгш хүртэх таатай нөхцөл бүрдүүлж, 500000 төгрөгийн хувь хүртээх журам боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4.8. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус секторт ажиллагсадын нийгмийн даатгалын хамрах хүрээ, үйлчилгээг жил бүр 15 хувиар нэмэгдүүлнэ.

1.4.9. Хүүхдийн ордон байгуулж өсвөр үе, хүүхэд, багачуудын өв тэгш, авъяас чадвараа хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлнэ.

1.4.10. Хүүхдийн эрх, хөгжил хамгааллыг сайжруулж, хүүхдийн төлөө болон хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.4.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэн, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлнэ.

1.4.12. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулж, нийгмийн дунд эрүүл идэвхитэй амьдрах нөхцөл бололцоог бий болгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

2.1. Аймгийн төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэн, зарлага санхүүжилтийг оновчтой хуваарилж, хэмнэлттэй зарцуулах, төрийн сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд:

2.1.1. ДНБ-д үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний хувийн жинг нэмэгдүүлэн, ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг хангаж, эдийн засгийн хөгжлийн хурдацыг нэмэгдүүлнэ.

2.1.2. Төсвийн төлөвлөлтийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн төлөвлөлт, санхүүжилт, тайлагналт, хяналтыг сайжруулан, хариуцлагын тогтолцоог бий болгоно.

2.1.3. Төсвийн урсгал зардлыг зохистой түвшинд хязгаарлан, эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөнүүд, үндсэн чиглэлд тулгуурлан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нь дээшлүүлнэ.

2.1.4. Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог боловсронгуй болгож, Засгийн газрын санхүүгийн удирдлага, мэдээллийн системийг өргөжүүлнэ.

2.1.5. Төрийн албан хаагчдад олгох говийн нэмэгдлийн хэмжээг 15000 төгрөгт хүргэнэ.

2.1.6. Аймгийн Бүртгэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ.

2.1.7. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд аудит хийлгэн, тэдний өнөөгийн байдал, хүрсэн түвшинг тодорхойлуулан, цаашдын гүйцэтгэл, үр дүн, нөлөөг сайжруулна.

2.1.8. Татварын бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, татвар төлөгчдийг идэвхижүүлэх, урамшуулах аргыг зохистой хослуулах арга хэлбэрийг боловсронгуй болгох, татвараа зайлшгүй төлөх, тайлагнах ухамсар, идэвхийг татвар төлөгчдөд төлөвшүүлж, татварын бааз суурийг өргөжүүлнэ.

2.1.9. Татвар хураалт, хяналтын бүхий л үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, удирдлага мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно.

2.1.10. Худалдан авах ажиллагааны хариуцлага, зохион байгуулалтыг сайжруулж, худалдан авах ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлнэ.

2.1.11. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, санхүүгийн зах зээлийн үйлчилгээг нэмэгдүүлэн түүний нийгмийн амьдралд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.

2.1.12. Санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөн, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн бүртгэл, мэдээлэл, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг улсын жишигт нийцүүлнэ.

2.1.13. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хяналтыг сайжруулж, орон нутгийн өмч хөрөнгийн нэгдсэн кодчилал, төрөлжилтийг хийж, мэдээллийн санг бий болгоно.

2.1.14. Төрийн болон орон нутгийн өмчийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хөрөнгийн өгөөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, удирдлагад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх замаар, шинээр хөрөнгө бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоно.

2.1.15. Статистикийн мэдээлэл боловсруулалтын бүх үе шатанд өртөг зардал багатай, шуурхай байдлыг хангасан техник технологийг нэвтрүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, мэдээллийн чанарыг дээшлүүлэн засаг захиргааны нэгжийг цахим сангаар хангана.

2.1.16. Банкны үйлчилгээнд сүүлийн үеийн дэвшилтэт техник хэрэгсэл, технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүний нэр төрөл тоог олшруулж, бага дунд орлоготой болон хөдөөгийн алслагдсан сумдын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр хүү багатай зээл болон барьцаагүй зээл олгох үйл ажиллагааг дэмжинэ.

2.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

2.2.1. Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор хангах зохион байгуулалтын арга хэмжээг авна.

2.2.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг илүүтэй дэмжин ажиллана.

2.2.3. Хүн амын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүн, ундны усны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.4. Атрын 3 дахь аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар төмс, хүнсний ногоогоор хүн амын хэрэгцээний 70 хувийг хангана.

2.2.5. Услалтын систем засварлах, шинээр барих ажилд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.2.6. Нутгийн уур амьсгалд тохирсон хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлж, нутагшсан сортын үрээр орон нутгийн хэрэгцээг хангана.

2.2.7. Жимсний эх суулгац үржүүлэх талбайг шинээр байгуулж, үр суулгацаар жимс үржүүлэгчдийн хэрэгцээг хангах замаар жимс жимсгэнэ тариалах талбайг 2 дахин нэмэгдүүлнэ.

2.2.8. Орон нутагт голомтлон гардаг болон мал амьтны болзошгүй өвчнүүдийг эпизотологийн судалгааны дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах хүрээг өргөтгөнө.

2.2.9. Мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж боловсон хүчнийг чадавхижуулна.

2.2.10. Малын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцаж, санхүүжүүлэх замаар эрүүл мал бүхий аймаг болохыг баталгаажуулна.

2.2.11. Нутгийн сонгомол омог хэвшлийн малыг цэврээр үржүүлэх замаар нутгийн эх сүргийн үржил, үйлдвэрлэлийн бааз суурь бий болгож, цөм сүргийн малын тоо толгойг өсгөнө.

2.2.12. Биотехнологийн ололтыг тууштай нэвтрүүлэх, өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.2.13. Бүсийн тулгуур төвүүд болон орд газруудыг түшиглэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, сумдын онцлогт тохирсон загвар фермер болон өрхийн аж ахуйг бодлогоор дэмжин зохицуулж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2.14. МААЭШХ-ийн Говийн бүсийн салбарын үйл ажиллагааг өргөтгөн тэмээ, ямаа судлалын чиглэлийн болон бэлчээрийн талхагдлыг бууруулах арга хэмжээг хавсран гүйцэтгүүлнэ.

2.2.15. Үерийн хөв далан байгуулж бэлчээр, газар тариаланг усжуулах, таримал бэлчээр бий болгох, талбай хаших зэргээр ургацыг нэмэгдүүлэх арга хэмжээг дэмжин урамшуулж, бэлчээрийн менежментийг сайжруулна.

2.2.16. Инженерийн хийцтэй уст цэг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг үргэлжлүүлэх, уст цэгийн геофизикийн эрэл хайгуулын ажлыг зохион байгуулах, энгийн уурхайн худаг гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж бэлчээрийн усан хангамжийг 85 хувьд хүргэнэ.

2.2.17. Малын тэжээлийн ургамал тариалах ажлыг өргөжүүлж, тэжээл боловсруулах үйлдвэр, цех байгуулна.

2.2.18. ХХАА-н салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо нөхөрлөл хэлбэрээр ажиллахыг бодлогоор дэмжинэ.

2.2.19. “Малчин” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2.20. Уул уурхайгаас орох орлогын зохих хувиар сан бүрдүүлж, төлөөр өссөн тэмээ тутамд мөнгөн урамшуулал олгох замаар тогтвортой өсөлтийг хангана.

2.2.21. Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд худалдаалах боломж бүхий мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулна.

2.3. Аймгийн дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэн хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах зорилтын хүрээнд:

2.3.1. Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдыг төвийн өндөр хүчдэлийн системд холбож байнгын цахилгааны найдвартай эх үүсвэртэй болгоно.

2.3.2. Улаанбаатар-Мандалговь-Таван толгой- Оюу толгой чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барина.

2.3.3. Тавантолгой-Даланзадгадын чиглэлд 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барина.

2.3.4. Нарийн сухайтын орд-Ноён, Сэврэй сумдыг 35/15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбоно.

2.3.5. Даланзадгадын ДЦС-ын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлж цахилгаан, дулаан хангамжийн найдвартай ажиллагааг хангана.

2.3.6. Цогт-Цэций, Баян-Овоо сумдын гадна дулааны шугам сүлжээг шинэчлэн засварлах, Даланзадгад хотын дулааны шугам сүлжээг ерөнхий төлөвлөлтийн дагуу шинэчлэн сайжруулна.

2.3.7. Даланзадгад хотын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн дэд станц, шугамыг ерөнхий төлөвлөгөөний дагуу орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглон кабель шугамаар шинэчлэн өргөтгөнө.

2.3.8. Аймгийн төвийн орон сууцуудыг хэрэглээний халуун устай болгох ажлыг хэрэгжүүлнэ.

2.3.9. Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлд хатуу хучилттай зам барина.

2.3.10. Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээ хүрэнгийн боомт чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгоно.

2.3.11. Орон нутгийн авто зам арчлалтын салбарын үйл ажиллагааг өргөтгөн бэхжүүлнэ.

2.3.12. Даланзадгад хот доторх 4,9 км хатуу хучилттай авто замыг шинээр барина.

2.3.13. “Гурван сайхан” нисэх онгоцны буудлын барилга байгууламжийг өргөтгөн олон улсын статустай болгоно.

2.3.14. Цогтцэций суманд орон нутгийн нисэх онгоцны буудал шинээр барьж ашиглалтанд оруулна.

2.3.15. Цогтцэций суман дахь Ухаа худаг уурхайгаас Гашуун сухайт хүртэл нарийн дан төмөр зам, дагалдах байгууламжийг барьж байгуулна.

2.3.16. Шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх зорилгоор нөхөн олговор олгож, орон нутгийн зорчигч, шуудан тээвэрлэлтийн хэвийн найдвартай ажиллагааг хангана.

2.3.17. Бүх сумдыг интернетийн сүлжээнд холбоно.

2.3.18. Сумдын үүрэн телефоны сүлжээг өргөтгөн, харилцах чадварыг нэмэгдүүлж, малчдын гар утас ашиглах боломжийг нэмэгдүүлнэ.

2.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан хот байгуулалт, газар ашиглалтын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

2.4.1. Аймгийн бичил бүсүүдийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, бүсийн төвүүдийг орчин үеийн төлөвлөлттэй төв суурин болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.2. Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаанд тулгуурлан орон нутгийн хөгжлийн бодлогыг шинэчлэн боловсруулж мөрдөнө.

2.4.3. Баруун бүс, Баяндалай, Хүрмэн сумдын хөгжлийн мастер төлөвлөгөөг Төвийн бүсийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж, бүсийн сумдыг хөгжүүлнэ.

2.4.4. Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.4.5. Даланзадгад сумыг загвар хот болгон хөгжүүлэх зорилгоор “Шинэ Даланзадгад” хотын ерөнхий төлөвлөгөөг бооловсруулан хэрэгжүүлж эхлэнэ.

2.4.6. Ноён, Мандал-овоо, Манлай, Сэврэй, Хүрмэн, Ханхонгор, Номгон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.4.7. Даланзадгад хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх замаар хот төлөвлөлтийг боловсронгуй болгоно.

2.4.8. Иргэн бүрд газар олгох тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд нь газар эзэмшүүлэх, хувийн орон сууц барихад нь дэмжлэг үзүүлэх зэргээр иргэдээ үл хөдлөх хөрөнгөтэй болгоход чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.9. “100000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон сууцны фондыг өсгөж, бага дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

2.4.10. Даланзадгад хотын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэчилж, зарим гэр хорооллыг төвлөрсөн системд холбох ажлыг үе шаттайгаар гүйцэтгэнэ.

2.4.11. Хүн амын ундны усан хангамжийг сайжруулах зорилгоор цэнгэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба орон нутагт нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

2.4.12. Цогтцэций, Гурвантэс, Ханбогд сумдын төвүүдийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугаманд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.4.13. Барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх үнэлгээ хийн паспортжуулж, мэдээллийн санг бий болгоно.

2.4.14. Орон нутгийн эрдэс түүхий эдийг түшиглэсэн барилгын материалын үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд дэмжиж ажиллана.

2.4.15. Төрийн захиргааны болон нийгэм соёлын байгууллагын барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлтийн ажлыг хийж, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулна.

2.4.16. Даланзадгад хотын төвийн гудамж талбай, гэр хорооллын гэрэлтүүлэг болон явган хүний замыг шинэчлэн засварлаж, хотын өнгө үзэмжийг сайжруулна.

2.5. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлснээр ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах зорилтын хүрээнд:

2.5.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санг өргөтгөж, зээлийн таатай орчинг бүрдүүлэн, төрийн зүгээс аж ахуй эрхлэхэд учруулдаг дарамтыг арилгана.

2.5.2. Төрийн захиргааны чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх замаар шинэ техник технологийг сурталчлах зуучлах ажлыг зохион байгуулна.

2.5.3. Даланзадгад суманд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, хөргөх зоорь, мал нядалгааны зориулалтын цэг болон ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, оёдлын үйлдвэр байгуулна.

2.5.4. Даланзадгад, Гурвантэс суманд тэмээний ноосон бүтээгдэхүүний үйлдвэр болон ноос угаах, барилгын материалын үйлдвэрүүдийг шат дараатайгаар байгуулна.

2.5.5. Сумдад жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 50 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй "Үйлдвэрлэл хөгжүүлэх сан" байгуулах замаар мал аж ахуйн гаралтай түүхий эд, орон нутгийн нөөцөд түшиглэсэн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг дунд үйлдвэрийг сум бүрт ээлж дараатайгаар шийдвэрлэнэ.

2.5.6. Даланзадгад суманд үйлдвэрлэл, бизнесийн ордон барьж, "Бизнес инкубатор"-ын үйлчилгээ үзүүлнэ.

2.5.7. Стандартчилал Хэмжил зүйн төвийн лабораторийг нарийвчлал өндөртэй эталон хэмжүүрээр хангаж, лабораторийн орчин нөхцлийг сайжруулна.

2.5.8. Хилийн боомтуудад хүнсний аюулгүй байдлын үзүүлэлт үзэх орчин үеийн лаборатори байгуулна.

2.6. Байгаль орчны менежментийг оновчтой болгон, байгалийн эвдэрсэн, элэгдсэн, бохирдсон орчныг нөхөн сэргээх, цэвэршүүлэх,

эрүүлжүүлэх ажлыг нэн тэргүүнд шийдвэрлэн, байгалийн нөөц баялагийг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилтын хүрээнд:

2.6.1. Нутгийн ард иргэдийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад байгалийн нөөц баялагийн тодорхой хэсгийг хуулийн хүрээнд хариуцуулан эзэмшүүлэх замаар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг сайжруулна.

2.6.2. Мод тарих, ойжуулах ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо нөхөрлөлийг хамруулан өргөжүүлж, урамшууллын механизмыг улам боловсронгуй болгон үр дүнг сайжруулна.

2.6.3. Аймгийн байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бий болгож, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.6.4. Булаг шанд, гол горхины эхийг хамгаалж усны нөөцийг нэмэгдүүлэх, зарим ширгэсэн булгийг сэргээх арга хэмжээг авна.

2.6.5. Даланзадгад болон бусад сумдын төв, суурин газрын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.6.6. Хот суурин болон авто замын дагуух газруудын агаар, ус хөрсний бохирдол, тоосжилтыг багасгаж, иргэдийн ажиллаж амьдрах эрүүл орчныг бүрдүүлэхэд чиглэсэн ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.6.7. Амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулж, тэдгээрийн байгалийн жамаар өсөн үржих, нөхөн сэргэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.

2.7. Говийн унаган байгаль, үзэсгэлэнт газрууддаа тулгуурлан бүсийн олон улсын нэгдсэн сүлжээнд холбогдсон хариуцлагатай аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд:

2.7.1. Аялал жуулчлалын гадаад, дотоод сүлжээг өргөжүүлж, БНХАУ-тай хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ энэ салбараас орон нутгийн ард иргэдэд тусах үр ашгийг нэмэгдүүлнэ.

2.7.2. Орон нутгийн онцлогийг харуулсан гадаадын жуулчдыг татахуйц “Үлэг гүрвэлийн парк”-ийг Булган сумын Баянзагт байгуулна.

2.8. Орчин үеийн техник, технологийг нэвтрүүлсэн, байгаль орчинд хохирол багатай, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, орлогын тодорхой хувийг орон нутгийн хөгжилд зарцуулдаг болох зорилтын хүрээнд:

2.8.1. Таван толгойн нүүрсний, Оюу толгойн зэс-алтны ордуудыг ашиглаж эхлэх ба эдгээр ордод түшиглүүлэн уул уурхай-металлурги-эрчим хүчний цогцолборыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.8.2. Ашигт малтмал олборлох, хайгуул судалгаа хийхээр зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй аймаг, сумын түвшинд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын талаар гэрээ байгуулж, хамтарч ажиллана.

2.8.3. Хууль тогтоомжийн хүрээнд орчин үеийн бичил уурхайг хөгжүүлнэ.

2.8.4. Ой, усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, бэлчээрийн нөөц бүхий газарт ашигт малтмал олборлохыг хориглох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсоох арга хэмжээ авна.

2.8.5. Ашигт малтмалын хайгуул судалгаа, олборлолтын үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг нээлттэй, ил тод болгож, иргэдийн тавих хяналтыг дээшлүүлнэ.

2.8.6. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үүднээс ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг чангатган, хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. НУТГИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

3.1. Иргэдэд үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага сахилгыг өндөржүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, суралцагч, манлайлагч байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. Мэргэжил, ур чадвартай боловсон хүчнээр төрийн жинхэнэ албаны нөөцийг бүрдүүлж, орон нутгийн боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлнэ.

3.1.2. Төрийн албан хаагчийн амьдралын нөхцөл бололцоо, ажлын үр дүн, тогтвор суурьшил зэргийг харгалзан тэтгэмж, тусламжид хамруулах, хөнгөлөлттэй зээл олгох, орон сууцны сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар нийгмийн баталгааг сайжруулна.

3.1.3. Боловсон хүчнийг гадаадын улс орнуудад мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд шат дараатайгаар хамруулна.

3.1.4. Төрийн байгууллагуудыг манлайлагч, суралцагч байгууллага болгон хөгжүүлж, өөрчлөгдөж буй орчинд зохицож чаддаг уян хатан, идэвхитэй санаачлагатай төрийн албан хаагчийг төлөвшүүлнэ.

3.1.5. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээний чадавхи, үр нөлөөг дээшлүүлнэ.

3.1.6. Засаг захиргааны анхан шатны нэгж болсон багийн хөгжлийг дэмжих замаар төрийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд ойртуулна.

3.1.7. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлэн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.8. Иргэдэд үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.1.9. Төрийн байгууллагын иргэдэд хүргэх үйлчилгээг ил тод, нээлттэй байлгаж, төрийн нууцаас бусад мэдээ, мэдээлэлтэй иргэд танилцах боломжийг бүрдүүлнэ.

3.1.10. Сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ.

3.1.11. Аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу бүсүүдийн жишиг сум, багийг бий болгоно.

3.1.12. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажиллах орчинг сайжруулах замаар үр дүнтэй ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

3.1.13. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах үүднээс аймгийн архивыг зориулалтын барилгатай болгож, сумдын архивын байрны стандартыг хангана.

3.1.14. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлнэ.

3.1.15. АНУ, Япон, Солонгос, ОХУ зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай хамтын ажиллагааны хүрээгээ өргөжүүлж, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллана.

3.1.16. БНХАУ-ын ӨМӨЗОрны аймгуудтай найрсаг харилцаатай байж, нийгэм эдийн засгийн бүхий л түвшинд хамтран ажиллана.

3.1.17. Гашуун сухайт-Шивээ хүрэнгийн хилийн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгож, гуравдагч хилийн боомт нээх асуудлыг судалж шийдвэрлэнэ.

3.2. Эрх зүйн шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэн, мэдээллийн хүрээг өргөтгөн, хүний эрх, эрх чөлөө, амьдрах аюулгүй орчныг хангах, түүнийг баталгаажуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилтын хүрээнд:

3.2.1. Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг судалж, төрийн үйлчилгээний хүнд суртал бий болгосон дүрэм, журмуудыг хуульд нийцүүлнэ.

3.2.2. Эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулан, иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээхэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлсэн бодлого баримтална.

3.2.3. Хууль тогтоомжийн лавламжийн сангийн системчлэл, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.

3.2.4. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, архидан согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлэн, сэтгэц наркологийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдаалах, түүгээр үйлчлэх, түүнд тавих хяналтыг сайжруулан, хяналтын тоонд нийцүүлнэ.

3.2.5. Иргэдийн амь бие, эд хөрөнгө, нэр төрийг гэмт халдлагаас хамгаалах, тэдний аюулгүй, амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэдийг татан оролцуулж, орон нутагт зонхилон гарч байгаа гэмт хэрэгтэй тэмцэнэ.

3.2.6. Хууль сахиулах байгууллагуудын тусгаарлах байрны орчин нөхцлийг стандартад нийцүүлэн сайжруулна.

3.2.7. “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа, боломжийг өргөтгөнө.

3.2.8. Иргэний биеийн өгөгдөл болон бусад төрлийн мэдээллийг агуулсан "Иргэний ухаалаг үнэмлэх" хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3. Хууль хяналтын болон цэрэгжсэн байгууллагын үйл ажиллагааг төр, захиргааны байгууллагуудтай уялдуулан зохицуулж, ажил үйлчилгээг иргэдэд ойртуулан, улсын хил хамгаалалтын чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Замын хөдөлгөөн, гудамж талбайд гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор телекамерийн хяналтын системийг Даланзадгад суманд бий болгоно.

3.3.2. Цагдаагийн хэлтсийг Цагдаагийн газар болгон өргөтгөх асуудлыг шийдвэрлүүлж Тавантолгойн нүүрсний уурхай, Гашуун сухайтын хилийн боомтыг хариуцсан гэрээт цагдаагийн тасаг байгуулна.

3.3.3. Цагдаагийн ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор цагдаагийн кобон барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.3.4. Нийгмийн хэв журмыг хамгаалах байгууллагуудыг зориулалтын техник хэрэгслээр хангах замаар хөдөлгөөнт эргүүлийн тогтолцоонд шилжүүлнэ.

3.3.5. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэргэжил, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын материаллаг баазыг сайжруулах арга хэмжээ авна.

3.3.6. Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтыг сайжруулна.

3.3.7. Гамшгаас сэргийлэх, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны шуурхай байдлыг хангана.

3.3.8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албыг бэхжүүлж, шийдвэр гүйцэтгэлийн ажлын үзүүлэлт, чанарыг дээшлүүлэн, шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг жил бүр 80-аас доошгүй хувиар хангаж ажиллана.

3.3.9. Терроризмаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг чиглүүлнэ.

3.3.10. Хил хамгаалах байгууллагын холбоо мэдээллийн тогтолцоо, хил хамгаалалтын техник хангамжийг шинэчлэх арга хэмжээ авна.

3.3.11. Хилийн застав, хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

3.3.12. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжих боломжийг бүрдүүлж, бүртгэл мэдээллийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулна.

3.4. Батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Хилийн болон Зэвсэгт хүчний анги салбаруудын бие бүрэлдэхүүний нийгэм, соёлын асуудлыг анхаарч дэмжлэг үзүүлнэ.

3.4.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлнэ.

3.4.3. Цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР